

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 11 (ТОЙМ)

Хуралдаан 2010 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 14.30 цагт эхэлж, 16.50 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 2 цаг 20 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Боловсролын баримт бичиг хуурамчаар ашигласан албан хаагчдын тухай	<p>1.Боловсролын хуурамч баримт бичиг ашиглан төрийн албан тушаалд томилогдсон нь нотлогдон энэ тогтоолын нэгдүгээр хавсралтад дурдагдсан нэр бүхий 37 иргэнийг төрийн тодорхой албан тушаалд томилсон шийдвэрийг хууль бус гэж тооцох,</p> <p>2.Энэ тогтоолын нэгдүгээр хавсралтад дурдагдсан нэр бүхий иргэдийг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 2010 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн дотор хүчингүй болгож энэ тухай шийдвэрээ Төрийн албаны зөвлөлд ирүүлэхийг томилох эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгох,</p> <p>3.Боловсролын хуурамч баримт бичиг ашиглан залилан мэхлэх замаар төрийн албанд томилогдох явдлыг илрүүлэх, таслан зогсоох, урдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар батлах,</p> <p>4.Энэхүү төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, улирал тутам Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд танилцуулж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Өнөбаатарт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов</p>
2	Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын орлогч даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын орлогч даргын албан тушаалд Төмөрчөдөрийн Гантөмөрийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов
3	Яам, агентлагийн дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний тухай	1.Яам, агентлагийн дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад зааснаар тус тус батлах,

		<p>2.Яам, агентлагийн дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарыг энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад зааснаар тус тус томилох,</p> <p>3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл байгуулах тухай” 2004 оны 04, 08, 20 дугаар тогтоолууд, “Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн тогтоох тухай” 2005 оны 16 дугаар тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн шинэчилсэн бүрэлдэхүүнийг батлах тухай” 2008 оны 08, 11 дүгээр тогтоолууд, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай” 2009 оны 14, 15, 17, 18, 19, 21, 22, 40, 72, 85, 88, 142, 169, 196 дугаар тогтоолууд, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай” 2010 оны 03, 26, 35, 196 дугаар тогтоолууд, “Төрийн албаны зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай” 2009 оны 197, 2010 оны 04, 25, 36, 197 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов</p>
4	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас төрийн захиргааны зарим албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах талаар ирүүлсэн саналын тухай	
5	Бусад асуудал	